



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?”

Улсын XIV олимпиадын удирдамж

Зорилго:

Жил болгон бүр уламжлал болон зохиогддог “Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?” улсын XIV олимпиадын зорилго нь эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр их, дээд сургуульд суралцдаг 1-р түвшний оюутнуудын дунд экономиксийн мэдлэг чадвар, авхаалж самбааг сорих, мэдээлэл солилцох, цаашид экономиксийг судлах сонирхлыг дэмжихэд оршино.

Оролцох оюутнууд:

- Монгол улсын эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалаврын сургалт явуулдаг их, дээд сургуулиудийн микроэкономиксийн үндэс, макроэкономиксийн үндэс хичээлийг өмнөх улиралд судалсан эсвэл энэ удиралд судалж байгаа 1-р түвшний (ангийн) оюутнууд оролцоно. Түүнчлэн экономиксийн үндэс хичээлийг судалсан 1-р түвшний оюутнууд оролцох боломжтой.
- Оюутнууд нь баг бүрдүүлж оролцох ба баг тус бүр нэг сургуулийн 4 оюутнаас бүрдсэн байна (анги, хөтөлбөр харгалзахгүй).
- Баг бүр оноосон нэртэй байна.

Олимпиадын журам:

Олимпиад 2 үе шаттай явагдана.

1 үе шат

2018 оны 4-р сарын 21-ний өдөр 11:00 цагаас МУИС-ийн хичээлийн IV ба V байранд явагдана. Оролцогчдын микро болон макроэкономиксийн суурь

мэдлэгийг тестээр шалгана. Багуудыг гишүүдийн авсан онооны нийлбэрээр байр эзлүүлнэ.

Хамрах сэдэв:

- Микроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд:

- Эдийн засгийн үндсэн зарчим
- Эрэлт ба нийлүүлэлтийн хууль, мэдрэмж
- Зах зээлийн тэнцвэр, татвар татаасын нөлөөлөл
- Пүүсийн онол: үйлдвэрлэл ба зардал
- Зах зээлийн хэлбэрүүд (төгс ба төгс бус өрсөлдөөнт зах зээл)

- Макроэкономиксийн үндэс хичээлийн дараах сэдвүүд:

- Үндэсний тооцооны систем
- Нийт эрэлт, нийт нийлүүлэлтийн загвар
- Нийт зарлагын загвар: Кейнсийн загвар
- Эдийн засгийн хэлбэлзэл, бизнесийн мөчлөг
- Сангийн бодлого

II үе шат

Эхний үе шатад шалгарсан хамгийн өндөр оноотой 8 баг олимпиадын хоёрдугаар үе шатад оролцоно. Хоёрдугаар үе шатны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгарсан багуудад хүргүүлнэ.

Шагналын сан:

Багийн дүнгээр: Нийт 3 баг шагналтай.

- 1-р байр 1: Өргөмжлөл, шилжин явах цом, 500,000 төгрөг
- 2-р байр 1: Өргөмжлөл, 400,000 төгрөг
- 3-р байр 1: Өргөмжлөл, 300,000 төгрөг

Хувийн дүнгээр: Нийт Зоюутан шалгаруулна.

- Тэргүүн байр 1: Өргөмжлөл, 150,000 төгрөг
- Дэд байр 1: Өргөмжлөл, 100,000 төгрөг
- Гутгаар байр 1: Өргөмжлөл, 75,000 төгрөг

Бүртгүүлэх журам:

Олимпиадад оролцох багуудыг 2018 оны 4-р сарын 9 – 18-ны хооронд ажлын өдөр бүр 10:00 – 18:00 цагт МУИС-ийн хичээлийн V байрны 6 давхарт бүртгэнэ.

Багуудыг багийн ахлагч эсвэл багийн гишүүн бүртгүүлж болно. Багийг бүртгүүлэхээр ирэх гишүүн нь дараах зүйлийг бүрдүүлж авчирна:

1. Багийн бүх гишүүдийн оюутны үнэмлэх, оюутны үнэмлэх байхгүй тохиолдолд 1-р түвшинд суралцаж буйг баталгаажуулсан өөрийн сургуулийн сургалтын албаны тамга бүхий албан тодорхойлолт.
2. Олимпиадын хураамж 20,000 төгрөгийг бэлнээр эсвэл Хаан Банк 5041076577 тоот дансанд (хүлээн авагч: Д. Дашдулам) хийсэн төлбөрийн хуудас. Хураамжийг дансанд хийсэн тохиодолд гүйлгээний утганд багийн нэр, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

Оролцогч та бүхэн muis.economy3@gmail.com цахим хаяг, 88168887, 88889900 дугааруудаас тодруулах зүйлээ асууна уу.

Хаяг: МУИС-ийн хичээлийн V байр 608 тоот

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх facebook event-ээс харна уу.

“Экономиксийн цагаан толгойг хэн сайн мэдэх вэ?” 2018

<https://www.facebook.com/events/1892855101012363/>

Утас: 88168887, 88889900

Хаяг: МУИС-ийн хичээлийн V байр, 608 тоот

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНХИМ

2018 он